ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/244/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdeneega@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Ахлах аудитор: Д.Алтайбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ............................................... **Error! Bookmark not defined.**
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ............................................... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ............................................... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ............................................... 4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ............................................... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ............................................... 6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ............................................... 8
3. Аудитын тайлан ............................................... 10
3.1 Ерөнхий зүйл ............................................... 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ............................................... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ............................................... 11
3.4 Материаллаг байдал ............................................... 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ............................................... 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ............................................... 12
3.6.1 Төсвийн төлөвлөлт ............................................... 12
3.6.2 Төсвийн гүйцэтгэл ............................................... 13
3.6.3 Нэмэлт төсөв ............................................... 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ............................................... 13
3.8 Аудитын гол асуудал ............................................... 13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ............................................... 13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ............................................... 13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ............................................... 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............................................... 14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ............................................... 14
4. Аудитын илрүүлэлт ............................................... 14
4.1 Залруулсан алдаа ............................................... 14
4.2 Төлбөрийн акт ............................................... 14
4.3 Албан шаардлага ............................................... 14
4.4 Зөвлөмж ............................................... 14

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СХЗГ | Стандарт хэмжил зүйн газар |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/180
танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТЦООЖ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **9,522,230.56** | **5,734,500.00** |
| **33** | **АВЛАГА** | **25,200.00** | **00.00** |
| **335** | **Бусад авлага** | **25,200.00** | **00.00** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 25,200.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **9,497,030.56** | **5,734,500.00** |
| **354** | **Хангамжийн материал** | **9,497,030.56** | **5,734,500.00** |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,084,300.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,412,730.56 | 5,734,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **156,732,994.18** | **152,566,952.68** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **156,732,994.18** | **152,566,952.68** |
| **392** | **Биет хөрөнгө** | **103,575,494.18** | **99,409,452.68** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 112,358,848.00 | 112,358,848.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -10,129,722.72 | -13,928,368.74 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 51,320,432.00 | 51,320,432.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -51,320,432.00 | -51,320,432.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 14,265,400.00 | 14,265,400.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -14,265,400.00 | -14,265,400.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,377,026.00 | 6,377,026.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -5,030,657.10 | -5,398,052.58 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **53,157,500.00** | **53,157,500.00** |
| 39301 | Програм хангамж | 750,000.00 | 750,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -750,000.00 | -750,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 53,157,500.00 | 53,157,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **166,255,224.74** | **158,301,452.68** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **166,255,224.74** | **158,301,452.68** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **166,255,224.74** | **158,301,452.68** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 169,019,103.00 | 169,019,103.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 169,019,103.00 | 169,019,103.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **-84,894,821.75** | **-92,848,593.81** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -84,894,821.75 | -84,894,821.75 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -7,953,772.06 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 82,130,943.49 | 82,130,943.49 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **166,255,224.74** | **158,301,452.68** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **149,832,630.00** | **211,439,450.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **23,342,430.00** | **59,658,150.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **23,342,430.00** | **59,658,150.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 23,342,430.00 | 59,658,150.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 23,342,430.00 | 59,658,150.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **126,490,200.00** | **151,781,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **126,490,200.00** | **149,511,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 126,490,200.00 | 149,511,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **00.00** | **2,270,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,270,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **134,199,216.51** | **219,393,222.06** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **134,199,216.51** | **219,393,222.06** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **95,443,616.51** | **193,014,131.05** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **71,772,308.00** | **141,159,824.13** |
| 210101 | Үндсэн цалин | 71,772,308.00 | 141,159,824.13 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **8,971,538.07** | **18,681,393.86** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,126,038.07 | 13,079,396.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 638,100.00 | 1,438,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 588,600.00 | 1,110,318.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 147,000.00 | 277,582.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,471,800.00 | 2,775,797.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **5,365,704.00** | **10,231,547.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 834,169.00 | 1,368,035.98 |
| 210302 | Түлш, халаалт | 4,089,846.00 | 7,270,844.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 441,689.00 | 1,592,666.42 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,280,675.44** | **9,416,830.56** |
| 210401 | Бичиг хэрэг | 330,800.00 | 860,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 758,550.00 | 3,741,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 693,595.44 | 1,864,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80,500.00 | 377,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 417,230.00 | 2,573,430.56 |
| **2105** | **Нормативт зардал** | **469,400.00** | **279,200.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 469,400.00 | 279,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,282,320.00** | **240,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,282,320.00 | 240,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,384,200.00** | **5,874,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,384,200.00 | 5,874,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **893,610.00** | **1,454,294.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 62,610.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 320,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 220,000.00 | 176,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 241,000.00 | 161,494.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 48,000.00 | 38,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 220,000.00 | 231,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 68,800.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 8,600.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 102,000.00 | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,023,861.00** | **5,676,541.50** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 150,000.00 | 397,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 96,500.00 | 1,113,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,777,361.00 | 4,166,041.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **38,755,600.00** | **26,379,091.01** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **38,755,600.00** | **480,000.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 38,755,600.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 480,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **00.00** | **17,899,091.01** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 17,899,091.01 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **00.00** | **8,000,000.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 8,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **15,633,413.49** | **-7,953,772.06** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **15,633,413.49** | **-7,953,772.06** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **C01** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **169,019,103.00** | **-80,396,247.57** | **170,753,798.92** |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **169,019,103.00** | **-80,396,247.57** | **170,753,798.92** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -5,925,582.74 | -5,925,582.74 |
| **C08** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **169,019,103.00** | **-84,894,821.75** | **166,255,224.74** |
| **D01** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **169,019,103.00** | **-84,894,821.75** | **166,255,224.74** |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **169,019,103.00** | **-84,894,821.75** | **166,255,224.74** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -7,953,772.06 | -7,953,772.06 |
| **D09** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **169,019,103.00** | **-92,848,593.81** | **158,301,452.68** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| 16------- Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **241,448,450.00** | **211,439,450.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **45,186,150.00** | **59,658,150.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **45,186,150.00** | **59,658,150.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **45,186,150.00** | **59,658,150.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 45,186,150.00 | 59,658,150.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **196,262,300.00** | **151,781,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **196,262,300.00** | **149,511,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 196,262,300.00 | 149,511,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **00.00** | **2,270,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 2,270,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **241,448,450.00** | **211,439,450.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **241,448,450.00** | **211,439,450.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **194,573,099.16** | **185,060,358.99** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **142,028,419.00** | **140,943,585.94** |
| 210101 | Үндсэн цалин | 100,464,611.00 | 103,782,578.40 |
| 210102 | Нэмэгдэл | 35,488,625.00 | 24,378,406.17 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,075,183.00 | 12,782,601.37 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **18,068,554.12** | **18,872,432.05** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,235,138.96 | 13,285,251.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,458,656.03 | 1,446,834.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,166,562.61 | 1,157,467.52 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 291,493.42 | 289,547.25 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,916,703.10 | 2,693,331.26 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **9,694,026.04** | **10,231,547.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,450,295.04 | 1,368,035.98 |
| 210302 | Түлш, халаалт | 7,270,843.00 | 7,270,844.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 972,888.00 | 1,592,666.42 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,862,700.00** | **6,417,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 830,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,183,000.00 | 2,646,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,393,000.00 | 1,864,100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 286,700.00 | 236,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,000,000.00 | 840,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,000,000.00** | **420,000.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,000,000.00 | 420,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,940,000.00** | **240,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,790,000.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 800,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,350,000.00 | 240,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **6,562,400.00** | **5,874,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,562,400.00 | 5,874,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,267,000.00** | **1,431,294.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 300,000.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 320,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 220,000.00 | 176,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 241,000.00 | 161,494.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 48,000.00 | 38,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 260,000.00 | 208,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 86,000.00 | 68,800.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 10,000.00 | 8,600.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 102,000.00 | 450,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,150,000.00** | **630,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 150,000.00 | 420,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 210,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **46,875,350.84** | **26,379,091.01** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **39,355,600.00** | **480,000.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 38,755,600.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 480,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **7,519,750.84** | **17,899,091.01** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,519,750.84 | 17,899,091.01 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **00.00** | **8,000,000.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 8,000,000.00 |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **-** | **-** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 183,831,300.0 | 183,270,359.0 | 560,941.0 | 99.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 183,831,300.0 | 183,270,359.0 | 560,941.0 | 99.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 183,351,300.0 | 182,790,359.0 | 560,941.0 | 99.7 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 139,219,900.0 | 138,836,975.8 | 382,924.2 | 99.7 |
| 210101 | Үндсэн цалин | 100,482,100.0 | 101,675,968.3 | -1,193,868.3 | 101.2 |
| 210102 | Нэмэгдэл | 34,579,800.0 | 24,378,406.2 | 10,201,393.8 | 70.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,158,000.0 | 12,782,601.4 | -8,624,601.4 | 207.4 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 18,794,700.0 | 18,709,042.2 | 85,657.8 | 99.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,225,900.0 | 13,121,861.4 | 104,038.6 | 99.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,392,200.0 | 1,446,834.8 | -54,634.8 | 103.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,113,800.0 | 1,157,467.5 | -43,667.5 | 103.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 278,400.0 | 289,547.3 | -11,147.3 | 104.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,784,400.0 | 2,693,331.3 | 91,068.7 | 96.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,987,200.0 | 10,231,547.0 | -1,244,347.0 | 113.8 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,048,400.0 | 1,368,036.0 | -319,636.0 | 130.5 |
| 210302 | Түлш, халаалт | 7,349,300.0 | 7,270,844.6 | 78,455.4 | 98.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 589,500.0 | 1,592,666.4 | -1,003,166.4 | 170.2 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,737,000.0 | 6,417,000.0 | -680,000.0 | 111.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 830,000.0 | 830,000.0 | 00.0 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,646,400.0 | 2,646,400.0 | 00.0 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,184,100.0 | 1,864,100.0 | -680,000.0 | 157.4 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 236,500.0 | 236,500.0 | 00.0 | 00.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 840,000.0 | 840,000.0 | 00.0 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 420,000.0 | 420,000.0 | 00.0 | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 420,000.0 | 420,000.0 | 00.0 | 00.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,440,000.0 | 240,000.0 | 1,200,000.0 | 16.7 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 640,000.0 | 00.0 | 640,000.0 | -100.0 |
| 210604 | Урсгал засвар | 800,000.0 | 240,000.0 | 560,000.0 | 30.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,929,900.0 | 5,874,500.0 | 55,400.0 | 99.1 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,929,900.0 | 5,874,500.0 | 55,400.0 | 99.1 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,192,600.0 | 1,431,294.0 | -238,694.0 | 120.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.0 | 320,000.0 | -320,000.0 | #DIV/0! |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 176,000.0 | 176,000.0 | 00.0 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 192,800.0 | 161,494.0 | 31,306.0 | 83.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 38,400.0 | 38,400.0 | 00.0 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 208,000.0 | 208,000.0 | 00.0 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 68,800.0 | 68,800.0 | 00.0 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 8,600.0 | 8,600.0 | 00.0 | 00.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 500,000.0 | 450,000.0 | 50,000.0 | -10.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,630,000.0 | 630,000.0 | 1,000,000.0 | 38.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 420,000.0 | 420,000.0 | 00.0 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,210,000.0 | 210,000.0 | 1,000,000.0 | -82.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 480,000.0 | 480,000.0 | 00.0 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 480,000.0 | 480,000.0 | 00.0 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 480,000.0 | 480,000.0 | 00.0 | 00.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 183,831,300.0 | 183,270,359.0 | 560,941.0 | 99.7 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 148,831,300.0 | 123,612,209.0 | 25,219,091.0 | -16.9 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 148,831,300.0 | 123,612,209.0 | 25,219,091.0 | -16.9 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 35,000,000.0 | 59,658,150.0 | -24,658,150.0 | 170.5 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,000,000.0 | 59,658,150.0 | -24,658,150.0 | 170.5 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 12.00 | 12.00 | 00.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 09.00 | 09.00 | 00.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02.00 | 02.00 | 00.00 | 100.0 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,270,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,270,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,270,000.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,106,610.14** |
| 210101 | Үндсэн цалин | 2,106,610.14 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **163,389.86** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 163,389.86 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,270,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,270,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,270,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгсөн.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн аудитор Г.Мөнхбаяр, гүйцэтгэх захирал Т.Батсайхан, чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Стандарт хэмжил зүйн хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 10 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Стандарт хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдлыг хамгаалах

- Үндэсний үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд стандартчилал, тохирлын үнэлгээний бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх
- Нийгэм эдийн засгийн хөгжлийн нэгдмэл байдлыг хангах, бодлогоор дэмжих, монгол улсын хөгжлийн тогтолцоо, хөгжлийн нэгжийн үндэсний эталон, хууль эрхийн хэмжил зүйн техникийн чадавхыг нэмэгдүүлж, олон улсын түвшинд хүргэх
- Бүтээгдэхүүн үйлчилгээний болон бүтээгдэхүүн үйлчилгээ, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын хамрах хүрээг өргөжүүлэх, худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, тэдэнд зах зээл дээр шударга өрсөлдөх таатай нөхцөлийг бүрдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт өөрчлөлт орж ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "13.5" хувьд өөрчлөлт орж "12.5" хувь, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж  "11.5" хувь болж өөрчлөлт орсон байна.
- Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дотоод зохион байгуулалт, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай стандарт хэмжил зүйн газрын даргын А/118 дугаар тушаал

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 3.6 сая төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 134.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 219.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр тогтоолоо. Энэ нь суурь үзүүлэлт өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.0 сая төгрөгөөр буюу 4.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данисууд байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулав.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/сая.төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Дансны авлага | 0.03 | - | (0.03) |
| Бараа материал | 9.50 | 5.73 | (3.76) |
| Үндсэн хөрөнгө | 156.73 | 152.57 | (4.17) |
| Биет бус хөрөнгө | 53.16 | 53.16 | - |
| **Нийт хөрөнгө** | **166.26** | **158.30** | (7.95) |
| **Эздийн өмч** | **169.02** | **169.02** | - |
| -төрийн | 169.02 | 169.02 | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 82.13 | 82.13 | - |
| Хуримтлагдсан үр дүн | (84.89) | (92.85) | (7.95) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **166.26** | **158.30** | (7.95) |

Мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн данс нь оны эцэст үлдэгдэл байхгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 0.03 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн авлагатай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 3.8 сая төгрөгөөр буурсан нь 5.9 сая төгрөгийн худалдан авалт, 9.6 сая төгрөгийн өмнөх оны нөөц болон зарцуулалттай холбоотой байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 4.2 сая төгрөгөөр буурсан нь барилга, байгууламж орон сууц болон тавилга эд хогшил данисуудын элэгдлийн зардалтай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 8.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 37.0 сая төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс хангамж, бараа материалын зардал 13.5 сая төгрөг буюу 27.6 хувь, норматив зардал 17.9 сая төгрөг  буюу 25.3 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 29.1 сая төгрөг буюу 27.3 хувиар буурсан нь гол нөлөө үзүүлжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс  сая төгрөгөөр тооцон төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг 183.8 сая төгрөг болгон бууруулан баталсан. Төсөвт тодотгол хийлгүйгээр урсгал санхүүжилт 0.7 сая төгрөг олгосон.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Стандарт хэмжил зүйн газраас 183.8 сая төгрөгийн төсөв батлагдсаны 149.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 35.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 211.4 сая төгрөг төвлөрүүлсэн. Үүнээс: Улсын төсвөөс 149.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 59.7 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 2.3 сая төгрөг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 219.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Төсвийн гүйцэтгэлийн тохиргоо 25.9 сая төгрөгийн залруулга хийсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Стандарт хэмжил зүйн газраас нэг удаагийн тэтгэмж урамшууллын санхүүжилт 2.3 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг хүлээн аваагүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд:

- Корона вирус цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- Корона вирус цар тахлын үед аймгийн онцгой комиссоос гаргасан төрийн албан хаагчдыг эргүүлд гаргах шийдвэрээр байгууллагын нийт албан хаагчид хамрагдаж урьд оны шатахууны үлдэгдэл талоныг тайланд онд зарцуулсан.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн Газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж нийт 0.6 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Үүнд: материаллаг хэмжээтэй цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 0.4 сая төгрөг, эд хогшил урсгал засвар 1.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1.0 сая төгрөг тус тус хэмнэсэн байна.

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх ёстой.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2021 онд нийт 142.9 сая төгрөгийн 18 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 11.4 сая төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.4.5, 6.4.8, заалтын хүрээнд “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ” мэдээллүүдийг хугацаа хоцруулан мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгахад:

- Шилэн дансанд байршуулах мэдээлэлд 2021 оны 2-р улирлын төсвийн гүйцэтгэл, эхний хагас жилийн санхүүгийн тайланг хугацаа хоцроож байршуулсан нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данс, бараа материал дансны ангилал, 1.1 сая төгрөгийн төсвийн төлөвлөлт зарцуулалттай /шатахууны талон/ холбоотой 3 зөвлөмж өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмжөөс төсвийн төлөвлөлт, зарцуулалт болон бараа материал дансны ангилалтай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийн байдлыг анхаарч үзэх нь зүйтэй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 36.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, төсвийн гүйцэтгэлийн тайланд 25.2 сая төгрөгийн алдааг залруулж, 11.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайланд дутуу тайлагнасан 25.2 сая төгрөгийг залруулав.

### 4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Шилэн дансны хууль тогтоомжтой холбоотой асуудал**

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Хөвсгөл аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2021 онд нийт 142.9 сая төгрөгийн 18 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 11.4 сая төгрөгийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Энэ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.4.5, 6.4.8,  заалтын хүрээнд “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ” мэдээллүүдийг хугацаа хоцруулан мэдээлсэн байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>*

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1 хэсэгт заалт, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 6.4.5, 6.4.8,  заалтыг хэрэгжилтийн биелэлтийг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хөвсгөл аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс | 2 | 36.6 | 1 | 25.2 | - | - | - | - | 1 | 11.4 |